

**XXI ЗУУНД ХАНДСАН ОРОС-ХЯТАДЫН ХАРИЛЦАА*****Л.Бэгзжав\****

Их гүрнүүдийн харилцаа, тэр дундаа манай улсын хоёр их хөрш ОХУ-БНХАУ-ын харилцааны байдал төлөв, чиг хандлага, олон улсын харилцаанд эзлэх байр суурийг анхааран үзэх нь тэдгээр гүрэнтэй харилцах явдлыг гадаад бодлогынхоо тулгуур болгодог Монгол улсын хувьд чухал ач холбогдолтой. Хүйтэн дайны дараах олон улсын нөхцөл байдал эрс өөрчлөгдөн манай умард хөрш ЗХУ задарч, олон улсын тавцан дээр ОХУ гэсэн цоо шинэ субъект үүссэн нь улс хоорондын харилцаанд нэгэн шинэ үзэгдэл болсон юм.

Хятад, Орос тус туслаа дэлхий дээр хүн ам хамгийн их, газар нутаг хамгийн том хоёр орон бөгөөд тус хоёр орны хооронд 4200 гаруй км хилийн шугам бий. Хүн амын тухайд Хятад нь Оросоос 8 гаруй дахин их, газар нутгийн хувьд Орос нь Хятадаас 1,8 дахин том<sup>1</sup>. Хоёр орон хоёул цөмийн зэвсэгтэй, хоёул НҮБ-ийн Аюулгүйн Зөвлөлийн Байнгын гишүүн орон, хамтдаа олон туйлт дэлхий ертөнцийг урагш ахиулах, олон улсын улс төр, эдийн засгийн шинэ дэг журам тогтоох талаар хамтын түүхэн чухал хариуцлага хүлээсэн юм. Орос –Хятад хоёр орны хүн ам дэлхийн хүн амын 1/4, газар нутаг нь дэлхийн хуурай газрын 1/5 хувийг эзэлдэг. Одоо Хятад улсын нийт хүчин чадал дэлхийд 7-рт байгаа ба дотоодын үйлдвэрлэлийн нийт өртөг жилд дунджаар 7%-иас дээш хурдацтай үргэлжлэн өссөөр байна. Оросын дотоодын нийт бүтээгдэхүүн жилд дунджаар 5%-ийн өсөлттэй байна. Хөгжлийн байдлаас харахад, XXI зуунд Орос-Хятад хоёр орон олон улсын улс төрийн тавцан дээр улам илүү үүрэг рольтой байх нь зайлшгүй. Орос –Хятад хоёр орон өдрөөс өдөрт өсөн дэвжиж буй их гүрэн, хоёр талын стратегийн хамтын ажиллагаа XXI зууны дэлхий дахины стратегийн байдалд чухал нөлөө үзүүлэх бөгөөд дэлхийн энх тайван, аюулгүй байдлыг хамгаалах ба тогтвортой байдалд чухал ач холбогдолтой байх болно.

\* Л.Бэгзжав - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, доктор (Ph.D), дэд профессор. Олон улс судлал<sup>2</sup> сэтгүүлийн ерөнхий менежер

\* \* \*

1991- 2001 он хүртэлх Орос- Хятадын харилцааг авч үзэхдээ Зөвлөлт –Хятадын харилцаанаас Орос –Хятадын харилцаанд шилжсэн шилжилтийн үеийг анхаарч үзэх нь зүйд нийцнэ.

Зөвлөлт-Хятадын харилцаанаас Орос- Хятадын харилцаанд ямар өв, юу үлдэв гэдэг асуудал гарна. 1989 оны тавдугаар сард ЗХУ-ын ерөнхийлөгч, ЗХУКН-ын Төв Хорооны Ерөнхий нарийн бичгийн дарга М.С. Горбачев Хятадал айлчилж, 30 жил завсарласаны эцэст Зөвлөлт –Хятадын дээд хэмжээний уулзалт анх удаа болов. Уулзалтын дараа “Зөвлөлт-Хятадын хамтарсан албан мэдээ” гаргав. 1991 оны тавдугаар сард ХКН-ын Төв Хорооны Ерөнхий нарийн бичгийн дарга, Цэргийн төв Зөвлөлийн дарга Зянь Зэминь ЗХУ-д айлчилж хоёр тал “Зөвлөлт-Хятадын хамтарсан албан мэдээ”-нд хоёрдахь удаагаа, бусад баримт бичигт гарын үсэг зурлаа.

Зөвлөлт-Хятадын удирдагчдын 2 удаагийн дээд хэмжээний уулзалтаар нэлээд хэдэн томоохон асуудлыг хэлэлцэж тохиролцсон юм. Үүнд :

1. Хоёр тал энх тайвнаар зэрэгцэн орших 5 зарчмын үндсэн дээр сайн хөршийн найрсаг харилцааг хөгжүүлэх
2. Аливаа маргааныг энх тайвнаар шийдвэрлэх, ямар ч хэлбэрээр зэвсэгт хүч хэрэглэхгүй буюу зэвсгийн хүчээр харилцан заналхийлэхгүй байх
3. Хил орчмын бүс нутагт цэргийн хүчийг багасгах
4. “Зөвлөлт –Хятадын хилийн дорнод хэсгийн хэлэлцээр”-т гарын үсэг зурж хараахан шийдвэрлээгүй байгаа хилийн асуудлыг үргэлжлэн хэлэлцэн тохирох
5. Хоёр орны эдийн засаг, худалдаа ба шинжлэх ухаан техникийн хамтын ажиллагааг идэвхитэй хөгжүүлэх, хоёр орны иргэдийн солилцоо, хамтын ажиллагааг өргөтгөх
6. ЗХУ Тайваны асуудалаарх БНХАУ-ын байр суурийг дэмжиж, Тайвань бол БНХАУ-ын салшгүй нэг хэсэг мөн гэдгийг хүлээн зөвшөөрөх
7. Олон улсын улс төр, эдийн засгийн шинэ дэг журам бий болгох<sup>2</sup> зэрэг болно.

Энд хоёр тал хэлэлцэн тохиролцсон зүйлс нь Зөвлөлт–Хятадын харилцаанаас Орос-Хятадын харилцаанд үлдээсэн өв болно. Энэ бол маргаангүй үнэт зүйл мөн. 1991 оны

арванхоёрдугаар сарын 25-нд ЗХУ задарсанаа зарласанаар ЗХУ-БНХАУ-ын харилцааны 42 жилийн түүх төгсгөл боллоо.

\* \* \*

1991 оны арванхоёрдугаар сард ЗХУ-ыг залгамжилсан ОХУ-тай БНХАУ дипломат харилцаа тогтоосноор хоёр орны харилцааны шинэ түүх эхлэв. ЗХУ задармагц 1991 оны арванхоёрдугаар сарын 27-нд Хятадын засгийн газрын төлөөлөгчид Москвад очиж, хоёр тал дараах чухал тохиролцоонд хүрсэн юм. Үүнд :

1. Орос улс бол хуучин ЗХУ-ыг залгамжлагч улс, НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн гишүүн орон мөн гэдгийг БНХАУ хүлээн зөвшөөрөв.

2. Хоёр тал энх тайвнаар зэрэгцэн орших 5 зарчим бол хоёр орны харилцааны үндэс суурь мөн. М.С. Горбачев 1989 онд Хятадад айлчлах үедээ гарын үсэг зурсан “Зөвлөлт-Хятадын албан мэдээ”-ний үндсэн зарчим бол хоёр орны харилцааны чиглүүлэгч зарчим мөн гэдгийг нотлон зөвшөөрөв.

3. Урьд нь Зөвлөлт-Хятадын гарын үсэг зурсан гэрээ ба гадаад харилцааны баримт бичгүүд хүчин төгөлдөр хэвээр байна.

4. Зөвлөлт-Хятадын хамтран хийсэн хоёр орны хилийн районы зэвсэглэлийг хорогдуулах, цэргийн салбарт итгэлцлийг бэхжүүлэх арга хэмжээний хэлэлцээр ба Зөвлөлт, Хятадын хилийн гэрээг үргэлжлүүлэн явуулж, аль болох хурдан хугацаанд нэгэнт хэлэлцэн тогтсон дорнод хилийн хэлэлцээрийг батлах, улмаар тодорхой болоогүй зурвас газрын талаар цаашид хэлэлцээр хийнэ<sup>3</sup> гэх мэт.

Өнгөрсөн 10 жилд хоёр орны харилцаа гурван шат ахилаа<sup>4</sup>. Үүнд 1991 оноос “найрсаг улс” байснаа, 1994 онд шат ахиж “XXI зуунд хандсан бүтээн байгуулалтын шинжтэй түншийн харилцаа”-нд орж, дараа нь дахин дээш ахиж 1996 онд “тэгш эрхтэй, харилцан итгэлцсэн, XXI зуунд хандсан стратегийн түншлэлийн харилцаа”-нд хүрэв. Орос, Хятад хоёр орон түүхэн туршлага сургамжаа гүнзгий нэгтгэн дүтнэж, өөр өөрсдийн бүтээн байгуулалт, хөгжлийн стратегийн хэрэгцээ шаардлага, үндэсний эрх ашгаа үндэс болгон, олон улсын байдлын өөрчлөлтийн шинэ хандлагад тулгуурлан, шинэ хэлбэрийн төрийн харилцаа тогтоолоо.

Оросын түрүүчийн ерөнхийлөгч Б.Ельцин БНХАУ-д 4 удаа

айлчилсан юм. Тэрээр 1992 оны арванхоёрдугаар сард анх удаа Хятадад айлчлахдаа 24 баримт бичигт гарын үсэг зурсаны дотор гол нь Орос-Хятадын харилцааны хамтарсан тунхаглал, Орос-Хятадын засгийн газар хилийн районы зэвсэгт хүчнийг хорогдуулах, цэргийн итгэлцэлийг бэхжүүлэх тухай меморандум, сансрын орон зайг энх тайвны зорилгоор ашиглах судалгааны талаар хамтран ажиллах хэлэлцээр болно<sup>5</sup>.

1994 оны есдүгээр сарын 2-6-нд БНХАУ-ын дарга Зянь Зэминь анх удаа Орост айлчилж, хоёр тал “Хятад-Оросын хамтарсан тунхаглал”-д гарын үсэг зурж, XXI зуунд хандсан стратегийн хамтын ажиллагааг хөгжүүлж, “шинэ бүтээлч түншлэлийн харилцаа” тогтоосноо зарлаж, урт хугацааны харилцааны үндсэн чиглэлийг тогтоов. Түүнчлэн стратегийн цөмийн зэвсгийг эсрэг этгээддээ хэрэглэхгүй, цөмийн зэвсгийг түрүүлж хэрэглэхгүй гэж тогтжээ. Хоёр орны удирдагчидын тодорхойлсон “эвсэлдэхгүй, эсрэгцэхгүй, гуравдахь орны эсрэг чиглээгүй” шинэ маягийн харилцаа нь Орос, Хятадын харилцаа амжилттай цаашид өрнөхөд чухал түлхэц боллоо. Айлчлалын үеэр Зянь Зэминь: “Хятад, Орос хоёул том гүрэн, мөн хөрш орон, манай хоёр орон хэдэн арван жилийн салхи шуургыг өнгөрүүлсэний дараа, аажмаар боловсорч байна. Эсрэгцэх ба эвсэлд нэгдэх нь хоёр орны эрх ашигт нийцэхгүй, гагцхүү энх тайвнаар зэрэгцэн орших 5 зарчмын үндсэн дээр сайн хөршийн найрсаг, харилцан ашигтай хамтын ажиллагааны харилцаа л сая хоёр орны үндсэн эрх ашигт үнэнхүү нийцэх ба дэлхийн энх тайван, хөгжилд ч ашигтай, иймээс ч хамгийн сайн сонголт юм”<sup>6</sup> гэж тэмдэглэсэн байна.

Эвсэлд үл нэгдэх, сөргөлдөхгүй байх нь шинэ цаг үед Орос, Хятадын харилцааны чухал онцлог юм. Түүхэн дээр, ЗХУ, Хятад хоёр холбоотны харилцаатай байсан ба сөргөлдөж байсан түүх ч бий. 50-иад оны эхээр шинэ Хятадын тусгаар тогтнол, бүрэн эрх, газар нутгийн бүрэн бүтэн байдал, социалист байгууллалыг хамгаалахын төлөө, ЗХУ БНХАУ-тай “Зөвлөлт-Хятадын найрамдалт холбоо, харилцан туслах гэрээ”-нд гарын үсэг зурсан юм.

Эвсэлд үл нэгдэх, үл сөргөлдөхийн дотоод агуулга нь хоёр орон гуравлагч оронтой эвсэл байгуулахгүй, гуравлагч орны эсрэг чиглэхгүй явдал байв. Урт хугацаанд, Зөвлөлт-Хятадын харилцаанд их бага хэмжээгээр гуравлагч орны хүчин зүйл нөлөөлсөөр байв. Тухайлбал, Зөвлөлт-Хятадын харилцааг хэвийн

болгоход “гурван том саад” гэгч ноцтой нөлөөлж байв. Үүний нэг нь Зөвлөлтийн цэргийг Монголоос гаргах асуудал байлаа. Орос-Хятадын дипломат харилцаа тогтоосноос хойш, хоёр орны гадаад бодлогын зохицуулалтыг дагалдан, хоёр талын харилцаанд гуравдагч орны хүчин зүйлийн сөрөг нөлөө илтэд буурч, гадаад ертөнцтэй харилцах харилцаа идэвхитэй нөлөө үзүүлэх болов. Орос – Хятадын стратегийн түншлэлийн харилцаа тогтоон хөгжүүлж, улмаар энэ нь бусад улсад нөлөөлөхгүй болж, түүний дотор АНУ зэрэг өрнөдийн орны харилцааг хамарч бүс нутгийн ба бүхий л дэлхий ертөнцийн тогтвортой байдлын чухал хүчин зүйл болж байв.

1996 оны дөрөвдүгээр сард Оросын ерөнхийлөгч Б.Ельцин Хятадад айлчлах үедээ хэдэн хэлэлцээрт гарын үсэг зурав. Түүний дотор эрчим хүчийг нээж ашиглах, атомын эрчим хүчийг энх тайвны үйлсэд ашиглах, сансрын уудмыг энх тайвны зорилгоор хамтран эзэмших хэлэлцээр, цөмийн аюулгүй байдлын салбарт хамтран ажиллах хэлэлцээр гол байр эзлэнэ. Мөн хоёр орон “Хятад-Оросын найрамдал, энх тайван хөгжлийн хороо”<sup>7</sup> байгуулав. Хоёр тал, хоёр орны Засгийн газрын тэргүүн нар тогтмол хугацаанд уулзаж байх механизм тогтож, мөн оны арванхоёрдугаар сард БНХАУ-ын Ерөнхий Сайд Ли Пэн Москвад айлчлав.

Хятад-Оросын харилцааг шинэ шатанд гаргасан энэ айлчлалын нэг гол үр дүн нь ХХI зуунд стратегийн хамтын ажиллагаа явуулахаар хоёр тал хэлэлцэн тогтсон явдал юм. Хятад-Оросын тэгш эрхтэй, харилцан итгэлцсэн түншлэл тогтоож, ХХI зуунд стратегийн талаар харилцан ажиллах нь ердийн нэг улс төрийн тунхаглал биш, харин Орос-Хятадын хамтын ажиллагаа чанарын шинэ түвшинд гарсаны бодит илэрхийлэл боллоо. Оросын тал БНХАУ-ыг бүс нутгийн хүчний төв болоод зогсоогүй дэлхийн хэмжээний их гүрэн болж байгааг хүлээн зөвшөөрөв.

1997 оны дөрөвдүгээр сарын 22-26-нд БНХАУ-ын дарга Зянь Зэминь Орост айлчилж, хоёр тал дэлхийн олон туйл ба олон улсын шинэ дэг журам тогтоох тухай “хамтарсан албан мэдээ”-нд Кремльд гарын үсэг зуржээ. “Албан мэдээ”-нд тэмдэглэхдээ: “хүйтэн дайны үзэл санааг эсэргүүцэж, бүлэглэх бодлогыг эсэргүүцэх хэрэгтэй”, “аливаа улс ямараар ч жанжлах, хүчээр түрээ барих бодлого явуулах, олон улсын үйл хэрэгт монополь эрх эдлэх ёсгүй”, “хоёр тал дэлхийн олон орон энх тайван тогтвортой байдлыг бий болгох, ил шударга зүй зохистой олон улсын шинэ

дэг журамын асуудлаар идэвхтэй яриа хэлцэл өрнүүлэхийг дэмжинэ” гэжээ. Олон туйлт ертөнц бол Хятад-Оросын стратегийн түншлэлийн харилцааны чухал үндсэн цэг мөн гэдгийг олон улс даяар хүлээн зөвшөөрч байна.

Мөн Хятад, Орос, Казахстан, Киргизстан, Тажикстан 5 гүрний тэргүүн нар хилийн бүсийн зэвсэгт хүчнийг хорогдуулах 5 талын хэлэлцээрт гарын үсэг зурсан юм.

Мөн оны арваннэгдүгээр сард Б.Ельцин Хятадад айлчилж, хоёр тал 8 баримт бичигт гарын үсэг зурсны дотор гол нь Хятад, Оросын Зүүн хэсгийн хилийн бараг 4200 км хилийн тэмдэглээний /баганын/ ажил дууссаныг зарлаж, баруун хэсгийн 55 км зурвас газрын тэмдэглээг тодотгох ажлыг эхэлжээ. Мөн хоёр тал эдийн засгийн хамтын ажиллагааг цаашид хөгжүүлэх хэд хэдэн хэлэлцээрт гарын үсэг зурсны дотор Хятадын орон нутгийн засгийн газар ба ОХУ-ын засгийн газрын хамтын ажиллагааны зарчмын тухай хэлэлцээр, Хятад, Оросын эдийн засаг ба шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны үндсэн чиглэлийн меморандум, Оросын Дорнод Сибириэс байгалийн хий дамжуулах хоолой тавих гэх мэт хэлэлцээр байв.

1998 оны арваннэгдүгээр сарын 22-25-нд БНХАУ-ын дарга Зянь Зэминь ОХУ-д “зангиагүй” айлчилал хийж, 3 дахь удаагаа хоёр тал “Хятад, Оросын XXI зууны харилцааны тухай хамтарсан мэдэгдэл” гаргав. Уг мэдэгдэлд хоёр тал олон улсын нийгмийн хөгжлийн гол хандлагыг тодорхойлж, цаашид хамтын ажиллагаагаа зузаатгах урт хугацааны стратегийн хэтийн төлөвөө хамтран зөвлөлдөв. Түүнчлэн Хятад, Оросын баруун хэсгийн хилийн газар нутгийн тодорхойлолтын ажлыг дуусгав.

1999 оны наймдугаар сарын 25-нд Зянь Зэминь Б.Ельцин нар Киргизстанд уулзахдаа стратегийн түншлэлийн харилцааг хөгжүүлэх асуудлыг хэлэлцжээ. 1999 оны арванхоёрдугаар сард Б.Ельцин Хятадад 4 дэх удаагаа айлчилж Зянь Зэминьтэй хоёр орны найрамдал, хамтын ажиллагааны харилцааг бүх талаар зузаатган гүнзгийрүүлэх талаар хамтын тохиролцоонд хүрэв<sup>8</sup>. Оросын ерөнхийлөгч Б.Ельцин БНХАУ-ын дарга Зянь Зэминь нар удаа дараагаар 9 удаа уулзаж хоёр орны удирдагчдын харилцан ойлголцол, итгэлшлэл нь хоёр талын харилцааны хөгжилд чухал үүрэг гүйцэтгэж чалахыг нотлон харуулав.

Орос, Хятадын харилцаа ямагт ийм түвшинд, тэгш замаар

явж ирээгүй нь нууц биш ээ. 1950-иад оны сүүлээс 60-иад оны дунд хүртэл Зөвлөлт, Хятад хоёр орон “марксизмыг хэрхэн ойлгох” “социализм байгуулах арга замын” талаар үзэл суртлын хурц ширүүн маргаантай байв. Үзэл суртлын талаархи зөрөлдөөн нь хоёр орны улс төрийн харилцааг ноцтой муутгаж байлаа. Хэрэг явдал хилийн мөргөлдөөн, зэвсэгт тулаанд ч хүрч байлаа. Энэ нь 1950 оны хоёрдугаар сарын 14-нд 30 жилийн хугацаатай байгуулсан “Зөвлөлт-Хятадын найрамдалт холбоо, харилцан туслалцах тухай гэрээ”-г үгүйсгэсэн хэрэг байлаа. БНХАУ-ын засгийн газар 1979 оны дөрөвдүгээр сарын 3-нд уг гэрээний хугацааг сунгахгүй тухай шийдвэр гаргаж байв. Тэр цагаас хойш хоёр орны хооронд хэрэг дээрээ олон улсын эрх зүйн ямар нэгэн үндэс суурь байхгүй явсаар ирсэн юм.

2000 оны долоодугаар сард Оросын шинэ ерөнхийлөгч В.Путин БНХАУ-д айлчилахдаа Орос-Хятадын харилцааны эрх зүйн үндэс болох шинэ гэрээ боловсруулах хэлэлцээ эхлэх талаар Хятадын талтай ярилцан тохиролцов. Айлчлалын өмнөхөн В.Путин “Хятад бол Оросын стратегийн түнш мөн” гэдгийг дахин нотолсон юм<sup>9</sup>.

Бүр 1989 оны тавдугаар сард Хятадын удирдагч Дэн Сяопин ЗХУКН-ын Төв Хорооны Ерөнхий нарийн бичгийн дарга М.С.Горбачевийг хүлээн авч уулзахдаа “өнгөрсөнөө хааж ирээдүйгээ нээе” гэж хэлсэн билээ. В.Путинтай уулзахдаа Зянь Земинь дээрх түүхэн үгийг давтан дурьдаад, өнөөгийн шатны хоёр талын харилцааг тодорхойлж, “өмнөх үеийнхэний буухиаг хүлээн авч, ирээдүйн харилцаагаа нээлттэй болгоё” гэж онцлон тэмдэглэсэн байна. 2000 оны дөрөвдүгээр сарын 18-нд Бээжинд Орос, Хятадын тунхаглалд гарын үсэг зурав. Бээжингийн тунхаглал нь хоёр орны стратегийн түншлэлийн Харт мөн<sup>10</sup>. Орос, Хятадын удирдагчид пуужин эсэргүүцэх хамгаалалтын асуудлаар хамтарсан мэдэгдэл хийж энэ талын гэрээг чанд сахиж мөрдөхөө илэрхийлжээ. Тэд энэ гэрээнд хориглосон пуужин эсэргүүцэх үндэсний систем байгуулах гэсэн АНУ-ын төлөвлөгөөг зэмлэн буруушаалаа. Бээжингийн тунхаглалд эрх тэгш, итгэлцлийн түншлэл, стратегийн харилцан ажиллагаа нь хоёр орны бүх талын хамтын ажиллагааг бэхжүүлэх, Орос, Хятадын ард түмний найрамдлыг бататгахад чухал ач холбогдолтойг онцлон тэмдэглэжээ. Энэ нь олон туйлт дэлхий ертөнц болон олон улсын шинэ, шударга, зүй зохистой дэг журмыг бүрэлдүүлэн тогтооход



тус дөхөм болно гэж тэмдэглэсэн байна.

Мөн тунхаглалд хоёр талын болон олон талын үндсэн дээр үндэсний салан тусгаарлах үзэл, олон улсын терроризм, шашны алан хядах үйл ажиллагаа, хил дамжсан гэмт хэргийн эсрэг идэвхитэй, үр дүнтэй, тодорхой алхам хийнэ гэж дурьджээ. Дээрх тунхаглалд стратегийн хамтын ажиллагааны материаллаг баазыг бэхжүүлэх, тухайлбал, БНХАУ-ын баруун бүс нутгийг хөгжүүлэх программд Орос улс оролцох, түүний дотор нефть, байгалийн хийн орд газрыг ашиглах, хий дамжуулах хоолой байгуулах боломжийг судлана гэж дурьдсан байна.

Айлчлалын явцад Бээжин хотноо хэд хэдэн хэлэлцээрт гарын үсэг зурав<sup>11</sup>. Үүнд:

- Оросын тусламжтайгаар Хятадад хурдан нейтроны реактор байгуулах хэлэлцээр. Энэ реактор нь Бээжингийн ойролцоо Хятадын атомын эрчим хүчний институтийн дэргэд баригдах ба 60 МВт хүчин чадалтай юм. Энэ байгууламжийг 4-5 жилд байгуулах ба үндсэн тоног төхөөрөмж, технологийг Орос улс нийлүүлэх болно.

- Эрчим хүчний салбарын хамтын ажиллагааг үргэлжлүүлэх тухай хэлэлцээр.

- Хятадын банк, Оросын Внешэконом Банкны хамтын ажиллагааны тухай хэлэлцээр.

- Боловсролын салбарт хамтран ажиллах тухай хэлэлцээр.

- Хятадын улсын нефтийн компани Оросын “ЮКОС” компаний хооронд нефть нийлүүлэх гэрээ, Ковыктины байгалийн хийн орд газрыг эзэмших төсөлд Өмнөд Солонгосын Согас компанийг оролцуулах тухай меморандум, нефть дамжуулах хоолойн талаар хамтран ажиллах цаашдын чиглэлийн протоколд тус тус гарын үсэг зурав.

Түлш эрчим хүчний салбарт хамтран ажиллах тохиролцоонд хүрсэн нь Хятадын хувьд чухал ач холбогдолтой. Хятадын эдийн засагчдын тооцоогоор 2010 он гэхэд тус оронд 90 сая тонн нефть импортоор авах зайлшгүй хэрэгцээтэй аж. Энэ нь Хятадад олборлохоор төлөвлөж буй нефтийн бараг тал хувь нь юм. Урьдчилсан тооцоогоор, Хятадад байгалийн хий олборлолт буурах ба 2005 онд 20 сая тонн байгалийн хийн хэрэгцээнийхээ дөнгөж 9 сая тонныг олборлох аж.

Хамтарсан баримт бичгүүдэд гарын үсэг зурсны дараа В.Путин Орос, Хятад хоёр “олон улсын аюулгүй байдлыг бэхжүүлэхэд



дорвитой хувь нэмэр оруулж чадна” гэж мэдэгдэв. Оросын ерөнхийлөгч Зянь Земиньтэй хэлэлцээ хийхдээ түүний хэлсэн “Холын садангаас ойрын хөрш дээр” гэсэн зүйр цэцэн үгээр илэрхийлсэн Хятадын хандлагыг хуваалцаж байгаагаа илэрхийлсэн байна.

В.Путиныг маш ажил хэрэгч удирдагч, Хятад, Оросын харилцааны нэн чухал болохыг ойлгож чадах хүн, улмаар бодит ажил хэргээрээ хоёр орны харилцааг цаашид хөгжүүлнэ гэж Хятадад үнэлж байна. Үүнийг тэрлэгч миний бие 2000 оны гуравдугаар сарын 29-ны орой Гуанжоу хотын эртний ном хэвлэлийн дэлгүүрээс “Путин КГБ-ын сургуулиас ОХУ-ын ерөнхийлөгч хүртэл”<sup>12</sup> гэсэн ном худалдан авсан юм. Сонирхолтой нь энэ өдөр В.Путиныг Оросын ерөнхийлөгчөөр сонгогдсоны дараахь 3 дахь өдөр байлаа. Хятадад өдөр дараалан ерөнхийлөгч Путины тухай шинэ ном худалдаанд гарч байсан нь Хятадууд Путины улс төрийн үйл ажиллагааг нарийн ажиглаж байсаны нэг илрэл биз ээ. “Оросын шинэ ерөнхийлөгчийн үеийн Орос-Хятадын харилцаа нь саад бэрхшээл, муруй тахиргүй, дэс дараатай хөгжиж байна” гэж Оросын эрдэмтэн А.Ларин дүгнэжээ<sup>13</sup>.

Оросын ерөнхийлөгч В.Путин “Дорнод дахь Оросын шинэ хэтийн төлөв” гэсэн өгүүлэлдээ Азид явуулах Оросын бодлогыг тодорхойлж: “Орос орон өөрийгөө Евроазийн улс гэдгээ ямагт мэдэрсээр ирсэн. Оросын газар нутгийн үндсэн хэсэг нь Ази тивд оршдогийг бид хэзээ ч мартаж байгаагүй. Харин энэ давуу талаа тэр болгон ашиглаж байгаагүйг шударгаар хэлэх нь зүйд нийцнэ. Ази, Номхон далайн бүс нутагт багтдаг улс орнуудын хамтаар амаар ярихаа ажил хэрэг болгож, эдийн засаг, улс төр болон бусад салбар дахь хэлхээ холбоогоо өргөжүүлэх цаг болсон гэж бодож байна. Үүнд шаардагдах бүхий л боломж өнөөдрийн Орос оронд бий” гээд цааш нь “Орос, Хятад улсууд далайцтай тэгтвортой байдлыг хадгалах жинтэй хүчин зүйл болох эрх тэгш, итгэлтэй түншлэлийг бий болгох бодлогыг тулштай баримтлаж байна”<sup>14</sup> гэж онцлон тэмдэглэсэн байна.

В.Путины БНХАУ-д хийсэн энэ айлчлал нь орчин үеийн дэлхийн хүчирхэг гүрэн болох БНХАУ-тай харилцах Оросын шинэ бодлогын эхлэлийг тавилаа<sup>15</sup> гэж Оросын улс төрийн нэрт тоймч Ф.Бурлацкий дүгнэсэн байна. Үнэхээр ч Орос-Хятадын хооронд харилцан сонирхол, эрх тэгш байдалд үндэслэсэн нөхөрсөг

харилцаа батжин тогтов. Энэ харилцаа үзэл суртлын маргаанаас ангид, олон улсын тавцан дээр улс төр, эдийн засгийн нягт хамтын ажиллагаа явуулахад тулгуурласан юм.

Орос-Хятадын харилцааны стратегийн түншлэлийн шинэ үеийн илэрхийлэл нь 2001 оны долоодугаар сарын 16-нд Оросын ерөнхийлөгч В.Путин, БНХАУ-ын дарга Зянь Зэминь нар Кремльд гарын үсэг зурсан “Орос, Хятадын сайн хөршийн харилцаа, найрамдал, хамтын ажиллагааны тухай Гэрээ”<sup>16</sup> юм. 20 жилийн хугацаатай энэ гэрээнд гарын үсэг зурсан нь хоёр орны харилцааны эрх зүйн үндсийг тодорхойлж, Хятад-Оросын харилцааны хөгжлийн явдал нэн чухал үйл явдал төлийгүй XXI зуун дахь олон улсын харилцааны түүхийн хуудсыг шинээр баяжуулсан чухал ач холбогдолтой үйл явдал боллоо.

Орос-Хятадын шинэ гэрээний нэг чухал зорилго бол хоёр орны хооронд харилцан итгэлцэлийн уур амьсгалыг бий болгох явдал байлаа. Хоёр тал нэг нэгнийхээ эсрэг түрүүлж цөмийн зэвсэг хэрэглэхгүй байх, стратегийн цөмийн пуужинг харилцан чиглүүлэхгүй байх үүрэг авахын зэрэгцээ газар нутгийн асуудал, улсын хилийн зааглалтыг зохицуулах талаар гэрээнд тодорхой заав. Хоёр орны хооронд хилийн шугамын асуудлаар 1964 оноос янз бүрийн маргаан гарсаар өнөөг хүрсэн юм. Орос-Хятадын 4249,79 км урт хилийн шугамыг үндсэндээ зааглан тогтоожээ. Зөвхөн 58 км урт хэсэг буюу Аргунь голын эхэн дэх Большой арал, Хабаровскийн район дахь Амур мөрний Большой Уссур, Тарабарын арлуудын хилийг л нарийвчлан тогтоогоогүй байгаа<sup>17</sup>. Иймээс гэрээнд энэ асуудлыг бүрэн зохицуулахыг тусгаж, “эдгээр асуудлыг шийдвэрлэхээс наана хоёр тал хараахан зөвшөөрөлцөөгүй хилийн хэсгийн статус-квог баримтлана” гэж заажээ.

“Хятад-Оросын сайн хөршийн найрамдал, хамтын ажиллагааны гэрээний чухал ач холбогдлыг улс төрч, судлаачид өндөр үнэлж байна.

БНХАУ-ын дарга Зянь Зэминь тэмдэглэхдээ: “шинэ зуунд хандсан, хойч үед хандсан энэ гэрээ нь шинэ зууны дунд үеийн Хятад-Оросын харилцааны хөгжлийн ерөнхий дүр төрхийг гаргасан, XXI зуунд хоёр талын харилцааны хөгжлийг чиглүүлэн заасан хөтөлбөрийн шинжтэй баримт бичиг мөн. Энэ бол Хятад-Оросын харилцааны хөгжлийн түүхэнд чигийг заагч ач холбогдолтой чухал үйл явдал юм. Хятад-Оросын гарын үсэг зурсан энэ гэрээ нь одоо

цагт амжилттай, олон жилд ашигтай үйл хэргийг үр хойч үедээ бий болгож байгаа явдал мөн”<sup>18</sup> гэсэн байна. Оросын Гадаад харилцааны сайд И.Иванов хэлэхдээ энэ “Гэрээ” бол хоёр орны харилцааны хөгжлийн замыг чиглүүдэгч хөшөө, хоёр орон хоёр ард түмний найрамдлын зам дээрх чиг заагч, хоёр их гүрний бүх талын хамтын ажиллагааг гүнзгийрүүлэн бэхжүүлсэн батламж бичиг мөн<sup>19</sup> гэсэн юм.

“Гэрээ”-ний ач холбогдолыг Хятадын Олон улсын стратеги судлалын хүрээлэнгийн тэргүүлэх ажилтан, доктор Янь Хуй “Хятад-Оросын Зууны гэрээ”-ний түүхэн ач холбогдол, алс хэтийн нөлөө” гэсэн өгүүлэлд онцлон дурьдсан юм<sup>12</sup>. Энэ “гэрээ” нь шинэ зууны эхэн үеийн олон улсын байдал ба их гүрнүүдийн харилцаанд гүн гүнзгий хувиралт гарсан үед, хагас зууны турши хоёр орны харилцааны сайн, муу хоёр талын туршлага сургамжийг гүнзгий нэгтгэн дүгнэснээрээ чухал ач холбогдолтой юм. “Гэрээ” бол Хятад Орос хоёр орны тэргүүн нар сүүлийн 10 жилд гаргасан хэд хэдэн тунхаглал, албан мэдээний гол зарчим, үзэл санааг нэгтгэн дүгнэж, бүр өндөр шатанд гаргасан юм. “Гэрээ” нь хоёр орон, хоёр ард түмэн “үеийн үед найрамдалтай, хэзээ ч дайсагналцахгүй байх” энх тайванч үзэл санааг хууль эрхийн үндсэн дээр байгуулж, хоёр тал хэзээд сайн хөрш, сайн түнш, сайн нөхөр байхын шийдвэртэй хүсэл эрмэлзэл, чин сэтгэлийн илэрхийлэл болжээ.

“Гэрээ”-ний улс төрийн агуулга нь XXI зууны Хятад-Оросын стратегийн түншлэлийн харилцааны гүн гүнзгий хөгжлийн улс төрийн үндэс суурийг баттай тавьж, 20 жилийн урт хугацаанд хүчин төгөлдөр байж, хоёр орны харилцааны тогтвортой хөгжлийг найдвартай хангах хууль эрх зүйн баталгаа мөн. Энэ “гэрээ” нь хоёр талын харилцаанд хоёр тал зайлшгүй хүндэтгэн сахих зарчим, хүлээсэн үүргийг тогтоож өгсөн юм.

“Гэрээ” нь хүйтэн дайны дараах олон улсын улс төр, эдийн засгийн шинэ дэг журам тогтооход, удирдлага болох ач холбогдолтой. Юуны өмнө, гэрээнд Хятад Орос хоёр улс “үеийн үед найрамдалтай, хэзээ ч дайсагнахгүй” гэсэн энх тайванч үзэл санаа илэрч байгаа ба дэлхийн энх тайван, тогтвортой байдал, хөгжил, хамтын ажиллагаанд ашигтай, олон туйлт ертөнцийг бий

болгох, шударга зүй зохистой олон улсын улс төр, эдийн засгийн шинэ дэг журам тогтооход тус дөхөм болно.

“Гэрээ” нь улс хоорондын харилцан хүндэтгэл, ижил талаа нэгтгэж, зөрөөтэйг нь орхих үлгэр жишээ, энх тайвнаар зэрэгцэн орших 5 зарчмыг удирдлага болгон хоёр орны харилцааны үндсэн хэм хэмжээг бодитой болгох, адил бус соёл иргэншлээс үүдэх зөрөлдөөнийг давах, өнөөгийн олон улсын харилцааны хөгжлийн чиг хандлагыг төлөөлж байна.

Энэхүү гэрээний үзэл санааг амьдралд хэрэгжүүлж БНХАУ-ын Төрийн Зөвлөлийн Ерөнхий сайд Жу Рунжи 2001 оны есдүгээр сарын 7-11 – нд ОХУ-д айлчлал хийлээ. Айлчлалын үеэр Оросын талтай хэд хэдэн шинэ хэлэлцээр хийв. Тухайлбал:

- 2005 он хүртэл Дорнод Сибирийн Эрхүүгийн бүс нутаг ба Хятадын Хармөрөн мужийг холбосон 2500 км урт нефть дамжуулах хоолойг ашиглалтанд оруулах

- Орос, Хятадыг холбосон байгалийн хий дамжуулах хоолойг түргэн барих

- Хятад-Оросын худалдааны хэмжээг 2000 оныхоос 30 хувь нэмэгдүүлж, 10 тэрбум ам.долларт хүргэх, Оросоос импортлох хэмжээг 40 хувь нэмэгдүүлж, 7,5 тэрбум ам.долларт хүргэх

- Хятад улс Оросоос 5 том иргэний агаарын нисэх онгоц худалдан авах /ТУ-204-120/ г.м. болно<sup>20</sup>.

Хятад-Оросын нефть дамжуулах хоолой нь цаашид хэдэн арван жил үргэлжлэх хоёр талын эдийн засгийн баттай суурь болох юм. Хятад улс 2000 оны есдүгээр сард Оросын Сибирь, Якутын бүс нутгийн нефть, байгалийн хийг ашиглах зөвшөөрөл авсан нь Зүүн хойт Азийн бүс нутаг дахь нөлөөний хүрээгээ ихээхэн тэлэх боломжтой болов. 2000 онд Орос-Хятадын худалдааны эргэлт 1999 оныхоос бараг 40% өсч, 8 тэрбум долларт анх удаагаа хүрэв. 2000 оны эцсээр Орост Хятадын хөрөнгө оруулалттай 400 үйлдвэр ажиллаж, гэрээнд зааснаар хөрөнгө оруулалтын хэмжээ 250 сая доллараас давжээ. Харин Хятадад 2000 онд Оросын оролцоотой 1160 үйлдвэр ажиллаж байгаа ч хөрөнгө оруулалтын хэмжээ нь 230 сая доллар байна. 2000 онд хоёр орны хил худалдаа 1999 оныхоос 65% өсч 3,14 тэрбум долларт хүрчээ<sup>21</sup>.

1991-2001 онд Орос, Хятадын цэрэг, техникийн хамтын ажиллагаа тогтвортой хөгжив. 2000 оны эцсээр Орос улс Хятадад зориулж шинэ зэвсгээр төхөөрөмжилсөн хоёр дахь эскадрын мина зөөгч онгоц бүтээж, Оросын агаарын цэргийн хүчний зэвсэглэлд ч ороогүй байгаа нисэх онгоцуудыг Хятадад анх удаа нийлүүлжээ<sup>22</sup>. Оросоос Хятадад нийлүүлэх орчин үеийн зэвсэглэлийн хэмжээ жилээс жилд өсч байна. 2001 онд Хятад улс Оросоос импортлосон зэвсэг техникийн хэмжээ 50-60 хувь өссөн ба 2002 онд ч энэ хурдацаа хадгалах аж<sup>23</sup>.

Ийнхүү хоёр орны удирдагчид тодорхой хугацаанд харилцан айлчлаж, төрийн тэргүүний дипломат бодлого идэвхтэй явуулж хоёр талын найрамдал хамтын ажиллагааг гүнзгийрүүлж буй нь Орос, Хятадын харилцаа эрүүл саруул, тогтвортойгоор үргэлжлэн хөгжихөд тустай юм.

Дүгнэж хэлбэл, Орос, Хятадын харилцаа нь Зөвлөлт-Хятадын харилцааг залгамжлан үргэлжлүүлж, шинэ стратегийн хамтын ажиллагааны түншлэлийн харилцааг бий болгож, Орос-Хятадын харилцааны олон улсын эрх зүйн үндсийг тавив. Хоёр орны 4200 гаруй км хилийг тодотгон тогтоов. Эдийн засгийн талаар, улам бүр хөгжиж буй худалдааны харилцаа нь харилцан ашигтай хамтын ажиллагааны зорилт болов. Хоёр орны удирдагчид тогтмол хугацаанд албан ёсны ба албан бус уулзалт хийдэг болсон нь улс төрийн харилцааг зузаатгаж байна. Чечений асуудал дээр, Орос улс, Хятадын тууштай байр суурийг дэмжиж байна. Цэргийн талаар хоёр улс батлан хамгаалахын хамтын ажиллагаагаа зузаатгаж байна. Олон улсын асуудлаар Хятад, Орос хоёр олон туйлт дэлхий ертөнцийг байгуулах, АНУ-ын дэлхийд дангаар ноёрхохыг эсэргүүцэж байна. Хоёр орон цаашид ч сайн хөршийн найрсаг, харилцан ашигтай байх үндсэн дээр стратегийн хамтын ажиллагааны түншлэлээ улам хөгжүүлэх болно.

Орос-Хятадын сайн хөршийн найрсаг харилцаа эрүүл саруул, тогтвортой хөгжих нь хоёр орны ард түмний үндсэн эрх ашигт төдийгүй, хоёр их гүрний дунд орших Монголын ард түмний эрх ашигт ч нийцэхсэн билээ. Орос, Хятадын харилцан бие биеэ дэмжсэн стратегийн түншлэл XXI зуунд үргэлжлэн хөгжих хэтийн төлөвтэй.

## ИШЛЭЛ, ЗҮҮЛГ:

1. 1.Л.Бэгзжав “Ирээдүйгээ нээхийн тулд өнгөрснөө хаая”. / Орос-Хятадын харилцаа/ “Тойм” сонин. 2001 оны 4-р сар №1
2. Жан Вэньмин. “Түншлэл үү, эсвэл сөргөлдөөн үү”. Нийгмийн Шинжлэх ухааны сурвалж бичгийн хэвлэлийн газар Бээжин. 2001: 146-р тал /хятад хэл дээр/
3. Мөн тэнд
4. Янь Хуй “Хятад-Оросын “Зууны гэрээ”-ний түүхэн ач холбогдол, алс хэтийн нөлөө”. “Гоцзы чжанлу яньцзю” /Олон улсын стратеги судлал/ сэтгүүл /хятад хэл дээр/ 2001:№4 11-р тал.
5. Ван Яньмин “Даго дэ минюань” /Их гүрнүүдийн хувь заяа/ Сычуаны ардын хэвлэлийн хороо. Чэнду, 2000
6. “Гоцзы чжанлу яньцзю” сэтгүүл. /Хятад хэл дээр/ сэтгүүл. 2001.№4 12-ртал
7. “Жэньминь жибао” /Ардын өдрийн сонин/ 1996.4.26. 1-р нүүрт .
8. “Жэньминь жибао” /Ардын өдрийн сонин/ 1999.12.11.
9. А.Лукин. Россия –Китай . “Международная жизнь”. 2001. №12. стр.78
10. “Парламентская газета” 19 июля 2000 г.№134
11. Мөн тэнд
12. Ян Цзинлун нар. “Путин: КГБ-ын сургуулиас ОХУ-ын ерөнхийлөгч хүртэл”, Орчин үеийн дэлхий ертөнц хэвлэлийн газар. Бээжин. 2000 оны 3-р сар
13. А.Ларин. Китайская политика России при Президенте В.В. Путине. “Проблемы Дальнего Востока”. №3. 2001 г. стр.11
14. Өнөөдөр” сонин, 2000.11.13
15. Ф.Бурлацкий “Новые приоритеты внешней политики России”, Парламентская газета, 28 июля, 2000 г. №141
16. “Парламентская газета” 17 июня 2001 г. №132
17. Ю.Бабич “Россия-Китай: трудный путь к взаимному доверию, “Парламентская газета” 19 июля. 2001 г. №133
18. “Гоцзы чжанлу яньцзю”. 2001 г. №4. 12-р тал
19. Мөн тэнд
20. “Цанкао сяоси” / “Лавлах мэдээ” / сонин. 2002. 1. 6. №15667
21. А. Лукин. “Россия – Китай” , “Международная жизнь”. № 12. 2001г. стр. 82.
22. А. Ларин . дурьдсан өгүүлэл. стр 13.
23. “Цанкао сяоси”. 2002. 1. 6. № 15667.